



# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЧ ХОЛБОГДОЛ

Улаанбаатар хот. 2020 он



# АГУУЛГА

<b>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА</b>	<b>3</b>
<b>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД</b>	<b>3</b>
<b>ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН</b>	<b>8</b>
<b>САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ ТАНД ЗӨВЛӨХӨД</b>	<b>9</b>
<b>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА БА ЛОМБАРДЫН ЯЛГАА</b>	<b>11</b>

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

---


Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлдэг хуулийн этгээдийг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/ гэж нэрлэдэг.

Санхүүгийн зах зээл дээр олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрснээр хэрэглэгчдэд өөрийн хэрэгцээ шаардлага, нөөц боломжид суурилсан үйлчилгээг сонгон авах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бичил, жижиг бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн санхүүжилтийн хэрэгцээг шийдвэрлэх

зорилгоор УИХ-аас 2002 онд “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийг баталж банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг хуулийн зохицуулалттай болгож байсан түүхтэй.

Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөр зээл, факторингийн үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ зэрэг 10 төрлийн санхүүгийн үйлчилгээг үзүүлдэг.

# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД



## ЗЭЭЛ:

ББСБ-уудын дийлэнх хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд энэ салбарын голлох бүтээгдэхүүн юм. ББСБ нь тодорхой хэмжээний хүүтэйгээр харилцагчдад санхүүгийн эх үүсвэрээ богино хугацаанд олох боломж олгодог. Зээлийн гэрээнд зээлийн хүү, эргэн төлөгдөх хуваарь, зээлдэгч зээлдүүлэгчийн эрх, үүргийг тусгана.

”  
Зээл авахдаа зээлийн гэрээний нөхцөлүүдтэй  
сайтар танилцаж, баталгаажуулж байгаарай.




## АНЗ БУЮУ АЛДАНГИ, ТОРГУУЛЬ ТООЦОХГҮЙ:

Иргэний хуулийн 452.2-т “Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй” гэж заасан байдаг тул эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн бол алданги, торгууль тооцохгүй бөгөөд харин үндсэн хүүгийн 20% хүртэлх **нэмэгдүүлсэн хүү** тооцож болно.

## ГАДААД ВАЛЮТЫН

**АРИЛЖАА:** Гадаад валютын арилжааг Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан ББСБ-ууд эрхэлнэ. Иргэн та валют солихдоо тухайн үйлчлүүлэгч тусгай зөвшөөрөлтэй эсэхийг нягталж, хуруугаа уншуулан үйлчилгээ авна.



Валют солихдоо гагцхүү ББСБ-ын нэрийн дансаар гүйлгээ хийгээрэй. Хувь хүний дансаар гүйлгээ хийж байвал тухайн этгээдээр дамжуулан валют солихоос татгалзаарай. Хэрвээ та хувь хүний данс руу мөнгөө шилжүүлэн валют солиулдаг бол тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй залилан мэхлэгчид мөнгөө алдах эрсдэлтэй.

Та гадаад валют солиулаад и-баримтаа дараах 3 төрлөөр авах боломжтой.

- Хэвлэмэл байдлаар
- И-баримт аппликейшнээр
- И-мэйл хаягаар



---

## МӨНГӨН ГУЙВУУЛГА:

Гадаадад байгаа гэр бүлийн гишүүн, найз нөхөддөө мөнгө шилжүүлэх болон гадаадаас мөнгө хүлээн авах шаардлага гарсан үед мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авдаг. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй этгээд нь энэ төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэхийг авна уу.



## ИТГЭЛЦЭЛ:

Итгэл хүлээлгэгчийн активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлдэг.



”  
**ББСБ-аас итгэлцлийн үйлчилгээ авахдаа тухайн байгууллага итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй эсэхийг нягталж үзээрэй.**

“

**ФАКТОРИНГ:** Энэ үйлчилгээ нь бараа материал худалдан авагч тал тухайн үед төлбөрөө барагдуулах боломжгүй бол факторингийн компаниар дамжуулан худалдагч талд төлбөрийг төлүүлэн дараа нь факторингийн компанид үндсэн төлбөр дээр тодорхой хэмжээний шимтгэлийг нэмж нийт төлбөрийг хэсэгчлэн болон бүхэлд нь төлөх гэрээ байгуулдаг.

---

## АЗИ НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР:

Монгол улс 2020 оны 9 сард Ази номхон далайн худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурж БНХАУ, Өмнөд Солонгос, Энэтхэг, Шри Ланка, Лаос, Бангладеш улсуудаас 10,667 нэр төрлийн бараа худалдан авахад 5-100 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломжтой боллоо. Татварын хөнгөлөлт эдлэх импорт, экспортын барааны жагсаалтуудыг <https://www.unescap.org/apta> сайтаар орж харна уу.

---




**ФИНТЕК:** Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг технологийн шийдэл ашиглан цахимаар хүргэхийг финтек гэж нэрлэдэг. Сүүлийн үед ББСБ-ууд гар утасны аппликэйшнээр дамжуулан харилцагчдад

бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэх финтекийн үйл ажиллагаа хурдацтай хөгжиж байна. Финтек зээлийн аппликэйшнд харилцагч мэдээллээ оруулснаар өр, орлогын харьцаа, зээлийн түүх, бусад мэдээллүүдийг хиймэл оюун ухаанаар боловсруулж харилцагчид олгох тохиромжтой зээлийн хэмжээг тодорхойлдог.

---

”  
Зээлийн аппликэйшнүүдийг ямар ББСБ-ын бүтээгдэхүүн болохыг тодорхой судалж, мэдсэний үндсэн дээр ашиглах нь ирээдүйд маргаан үүсэхээс сэргийлэх, Санхүүгийн зохицуулах хороонд хандан эрхээ хамгаалуулах, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг чухал ач холбогдолтой.

“



**ЦАХИМ МӨНГӨ, ХЭТЭВЧ:** Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Үндэсний төлбөрийн системийн төлбөр тооцоо гүйцэтгэх, төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрлүүдийг Санхүүгийн

зохицуулах хороо, Монголбанкнаас авч цахим хэтэвчийн үйлчилгээг харилцагчдад хүргэн ажиллаж байна. Цахим мөнгө, хэтэвчийг ашигласнаар цаг хугацаа хэмнэж, хэрэглээгээ хөнгөвчилж, төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэх боломжийг олгож байгаагаараа давуу талтай.



### **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:**

Та банк бус санхүүгийн үйлчилгээ авахаар гаргаж өгсөн аливаа цахим болон хэвлэмэл мэдээллийг тухайн ББСБ нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэхээс өөр байдлаар ашиглах, бусдад задруулах нь хуулиар хориотой бөгөөд мэргэжлийн санхүүгийн байгууллага нь мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй юм.

## ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН



Банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авч буй харилцагчдын зээлийн эргэн төлөлт нь хэвийн, хугацаа хэтэрсэн эсэх талаарх мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд нийлүүлдэг. Зээлийн гэрээнд заасан зээлийн эргэн төлөлт хийх хуваарьт өдөрт зээлээ төлөлгүй хугацаа хэтэрсэн бол хэд хоногоор хугацаа хэтэрснээс нь хамааран ангилдаг. “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу активыг дараах байдлаар ангилдаг.

№	Зээлийн ангилал	Үндсэн төлбөр, хүүгийн төлөлт хийгдэлгүй хугацаа хэтэрсэн хоног	
1	Хэвийн	1-30	
2	Анхаарал хандуулах	31-90	
3	Чанаргүй	Хэвийн бус	91-180
4		Эргэлзээтэй	181-360
5		Муу	361-ээс дээш

Зээлдэгчийн мэдээлэл нь Зээлийн мэдээллийн санд хадгалагддаг ба харилцагч банк санхүүгийн байгууллагаас үйлчилгээ авахад нь тухайн харилцагчийн зээлийн түүхийг харгалзан үзсэний үндсэн дээр зээл олгох шийдвэр гаргадаг. Тиймээс зээлдэгч нь зээлийн түүхээ сайн байлгахын тулд зээлийн эргэн төлөлтөө хугацаанд нь хийж хариуцлагатай байх хэрэгтэй.

### ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ТАНЫ МЭДЭЭЛЭЛ БУРУУ БҮРТГЭГДСЭН БОЛ ЯАХ ВЭ?

1. Харилцагч та зээл авсан ББСБ-даа зээлийн мэдээллийн санд мэдээлэл нь буруу бүртгэгдсэн байгааг засуулах хүсэлтээ гаргана.

2. Таны зээл авсан ББСБ буюу зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлсэн ББСБ нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд таны мэдээллийг засуулах хүсэлтийг гаргана.
3. Зээлийн мэдээллийн сан хүсэлтийг хүлээн авч мэдээллийг шинэчилнэ.

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ ТАНД ЗӨВЛӨХӨД

---



### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Санхүүгийн үйлчилгээ авах гэж буй тухайн байгууллага нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан эсэхийг <http://www.frc.mn/> сайтаар орж зохицуулалтын салбарууд цэснээс харж баталгаажуулна уу.

### ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛҮҮДИЙГ САЙТАР УНШИЖ, ОЙЛГОЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ!



Иргэд санхүүгийн байгууллагаас зээл авахдаа гэрээний нөхцөлөө сайтар уншиж танилцалгүйгээр гарын үсэг зурж тухайн гэрээ хүчин төгөлдөр болсон хойно буруу ойлголттой явснаас болж зээлийн гэрээний маргаан их

гардаг. Тиймээс өөрийн эрх, үүрэг, хариуцлагыг сайтар ойлгосны дараа гэрээн дээр гарын үсэг зурна уу.

---

---

## БУСДАД ӨӨРИЙН НЭР ДЭЭР ЗЭЭЛ АВЧ ӨГӨХГҮЙ БАЙХ!



Сайн таньдаг хүн тань өөрийнхөө нэр дээр зээл авах боломжгүй тул таны нэр дээр зээл аваад зээлийн төлөлтийг хийе гэвэл та зөвшөөрөх үү?

Сэтгэлийн хөдлөлөөр яаран зээл авч өгөхөөсөө өмнө сайтар бодоорой, залилан мэхлэгчдийн хохирогч болох эрсдэлтэй тул болгоомжтой хандаж, аль болох бусдын өмнөөс санхүүгийн хариуцлага үүрэхгүй байх нь таныг эрсдэлээс хамгаална.



---

## ӨРИЙН ДАРАМТАД ОРОХГҮЙ БАЙХ:

Та зээл авахдаа өөрийн орлого, зээлээ эргэн төлөх боломжид тохируулан өрийн дарамтад орохгүй байхаар тооцоорой. Монголбанкны “Өр орлогын харьцаа тооцох журам”-ын дагуу зээлдэгчийн өр нь орлогын 60% хүртэл байхаар заасан байдаг тул өөрийн санхүүгийн шийдвэр гаргалтад дээрх харьцааг жишиг болгон ашиглах боломжтой юм.



---

## ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН АШИГЛАН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА:

Та гар утасны аппликейшнээр дамжуулан зээл авах, мөнгөн гуйвуулга хийх, итгэлцлээр мөнгө байршуулах зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ авахдаа **“Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрч байна”** гэсэн товчийг дарахаас өмнө үйлчилгээний нөхцөлтэй маш сайн танилцах хэрэгтэй.



## САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА ХУВИЙН ДАНСААР ГҮЙЛГЭЭ ХИЙХГҮЙ БАЙХ:

Та валют солиулах, мөнгөн гуйвуулга хийх, зээлийн эргэн төлөлт хийх, итгэлцлээр мөнгө байршуулах зэрэг үйлчилгээ авахдаа тухайн байгууллагаа банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж, аливаа мөнгөн шилжүүлэг, гүйлгээг тухайн байгууллагын нэр бүхий данс руу хийгээрэй. Хувь хүний дансаар гүйлгээ хийхийг санал болговол та татгалзаарай.

*Санхүүгийн зах зээл дээр тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдтэй таарвал Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх хэрэгтэй. Ингэснээр та өөрийгөө болон бусдыг залилан мэхлэгчдийн буруутай үйлдлийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх юм. Мөн таньдаг хүн тань валют сольж өгнө гээд хувийн дансаар мөнгө шилжүүлж авдаг бол байгууллагын дансыг нь асууж, гүйлгээгээ хийгээрэй.*



## ЭХ ҮҮСВЭР НЬ ТОДОРХОЙГҮЙ МӨНГИЙГ ДАНСААРАА ОРУУЛЖ ГАРГАХГҮЙ БАЙХ:

Хувь хүний гар дээрээс бэлнээр валют худалдаж авах, хэн нэгний хүсэлтээр өөрийн дансаараа дамжуулан мөнгө оруулж гаргах зэрэг нь таныг **Мөнгө угаах,**

**терроризмыг санхүүжүүлэх** гэмт хэргийн хохирогч болгох эрсдэлтэй юм.

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА БА ЛОМБАРДЫН ЯЛГАА

---

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг өөр нэг төрлийн байгууллага нь барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд буюу ломбардууд юм. Энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид нь Монгол улсын Иргэний хуулийн 286 дугаар зүйл болон Стандарт, хэмжил зүйн газрын “MNS 5274:2017 Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, нийтлэг шаардлага” стандартын дагуу зохицуулагддаг бөгөөд тусгайлсан хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна. Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчид нь дээрх стандартын дагуу харъяа орон нутгийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлж үйл ажиллагаа эрхэлдэг.



Ломбардууд нь компьютер, үнэт эдлэл, цаг, машин, гар утас зэрэг бүх төрлийн хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгодог. Харин банк бус санхүүгийн байгууллагууд нь үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгодог. Банк бус санхүүгийн байгууллага болон ломбардын зээлийн хүү болон хугацаа нь өөр байдаг. Харилцагчид эдгээр байгууллагаас зээл авахдаа банк бус санхүүгийн байгууллага, ломбард аль нь болохыг нягталж хэрвээ маргаан гарвал ямар байгууллагад хандах зэргийг судлаж, мэдсэний дараа үйлчилгээ авах байгууллагаа сонгож үйлчлүүлээрэй.

## ГЭРЭЭНИЙ МАРГААН ҮҮСВЭЛ ЯАХ ВЭ?



### **Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан бол:**

Санхүүгийн зохицуулах хороонд гараар өргөдөл бичиж өгөх эсвэл [frc.mn](http://frc.mn) сайтаар нэвтэрч цахимаар өргөдөл гаргаж холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлнэ.

### **Ломбардаас зээл авсан бол:**

Иргэний хуулийн дагуу шүүхэд хандаж асуудлыг шийдвэрлүүлнэ.



[www.frc.mn](http://www.frc.mn)



51-264444



[webmaster@frc.mn](mailto:webmaster@frc.mn)



[www.facebook.com/FRC.of.Mongolia](https://www.facebook.com/FRC.of.Mongolia)



Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160